

## IV ХЭСЭГ

## Нийгмийн аюул ба шийдэл

Бүлэг	Хуудас
19. Өчүүхэн бага орлогын төлөө хэт хурдан, хэт их ажиллах.....	364
20. Үйлдвэрийн ажлыг гэртээ хийх .....	386
21. Ялгаварлан гадуурхал.....	398
22. Хүчирхийлэл .....	417
23. Шилжин ирсэн ажилчид .....	438
24. Ажил хийдэг хүүхдүүд .....	455
25. Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж .....	468
26. Нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд.....	490
27. Стресс ба сэтгэцийн эрүүл мэнд .....	510
28. Эрүүл мэндэд тустай хооллолт .....	529
29. Аюулгүй цэвэр ус ба жорлонгийн хүртээмж .....	539
30. ХДХВ (Хүний Дархлал Хомсдолын Вирус) .....	545
31. Сүрьеэ (ТВ).....	558
32. Амьдрахад таатай газар.....	563
33. Үйлдвэрийн хог хаягдал .....	569

## 19

## Өчүүхэн бага орлогын төлөө хэт хурдан, хэт их ажиллах



Экспортын чиглэлийн үйлдвэрийн дарга нар аль болох бага мөнгөөр аль болох их бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг ажилчдаасаа хүсдэг. Ингэхийн тулд тэд ажилчдад аль болох багыг өгч ихийг авахын тулд өдөржингөө, илүү цагаар хэт их хурдтай ажиллуулдаг. Ажилчид бараг үүнийг хийхээс өөр сонголтгүй учир ажлаа алдчихалгүй, хангалттай мөнгө олж амьдрахын тулд хий гэсэн бүхнийг нь хийдэг.

Гэвч ажлыг хүн зохион байгуулж, бас хүн л түүнийг өөрчилж чаддаг. Ажилчид, тэднийг дэмжигч олон нийт, тэдний үйлдвэрлэдэг барааг худалдан авдаг байгууллага, хувь хүмүүс л ажил олгогчдоос өөрсдийн үүргээ биелүүлэхийг нь шаардаж чадна.

- Амьдрахад хүрэлцэхүйц цалин хөлс өг, тэгснээр ажилчид хангалттай сайхан амьдрахын тулд илүү цагаар ажиллах шаардлагагүй болно;
- Өдөрт амрах, хоол идэх завсарлага өгөх;
- Албадан илүү цагаар ажиллуулахыг хориглох;

- Өвчтэй болон жирэмсэн байсан хугацааны цалинг өгөх;
- Ажилчдад бүх амралт, баярын өдрүүдийн амралт, мөн долоо хоногт дор хаяж нэг хоногийн амралт өгөх;
- Дамжлагын хэт их хурд болон үйлдвэрлэлийн өндөр нормоос болж гэмтэж байгаа шалтгааныг арилгах.

Олон оронд ажилчдын цалин хөлс, ажиллах цаг болон ажлын нөхцөлийг хуульчилсан байдаг. Гэвч засгийн газар ихэвчлэн хуулиа сахиулж чаддаггүй.

## Бид робот биш

Хүн бүрт амрах, амсхийх, тайвшрах, бас гэр бүл, нийгмийн амьдралд оролцох цаг хугацаа хэрэгтэй байдаг. Гэвч ажил олгогч биднийг хэзээ ч өвдөлт мэдэрдэггүй, дурладаггүй, гэр бүлгүй, хэзээ ч өвддөггүй, бас үйлдвэрээс гадуур амьдралгүй робот мэт ажиллуулахыг хүсдэг. Тэд ажилчдыг хэзээ ч гомдоллодоггүй, асуулт асуудаггүй, шаардлага тавьдаггүй робот шиг байлгаж, ажилчдыг өөрсдийг нь өвчлүүлж, ядрааж, ядуу болгож байгаа ч гэсэн үйлдвэрийн системийг өөрчлөхгүйгээр энэ хэвээр нь байлгахыг л хүсдэг.

Хэтэрхий хурдан эсвэл хэт олон цагаар ажилласнаар илүү их стресст орж, гэмтсэн үе мөч, булчингаа хэтрүүлэн ажиллуулж илүү их гэмтэж бэртэхэд хүргэдэг (7-р бүлэг: Эргономик хэсгийг үз).



**Ажилчид бид ч бас эцэг эхчүүд.**

## Стресс

Хэт олон цагаар ажиллах нь хүнийг өөртөө эсвэл гэр бүлдээ санаа тавих хэрэгцээт цаггүй болгодог. Ажлын дарамт нь бидэнтэй хамт гэрт ирж, биднийг бухимдуулж, бас сэтгэл санааг тогтворгүй болгодог. Хэт их “стресст орох” нь биеийн болоод сэтгэцийн эрүүл мэндийн төрөл бүрийн өвчин, зовуурь луу хөтөлдөг.



Олон цагаар ажилласнаас болж эмэгтэйчүүд илүү их стресст өртдөг. Учир нь тэд ажлаа тараад гэртээ ирэхэд гэр бүлдээ санаа тавих бүүр их ажил хүлээж байдаг (21-р бүлэг: Ялгаварлан гадуурхал хэсгийг үз).

## Ядаргаа

Ядаргаа нь таны бие гэрийн болон ажлын ачааллыг дааж чадахгүй болсноос үүсдэг. Энэ нь ихэвчлэн урт удаан ажлын өдрийн дараа мэдрэгддэг бөгөөд энэ нь зүгээр л нэг ядарсан мэдрэмж биш юм. Ядаргааны өндөр түвшинд хүрсэн хүмүүсийн хэтийдсэн ядаргаа нь унтаж амраад ч арилдаггүй. Магадгүй таны булчин болон үе мөч өвдөж, гэдэс дотор зовуурилж, арьсан дээр тууралт гарч, хоолой өвдөж, бас толгой өвдөж болно. Эмэгтэй хүмүүст ихэвчлэн сарын тэмдгийн мөчлөг алдалт, шалтгаангүй цус алдалт, үр зулбалт эсвэл жирэмслэлттэй холбоотой бусад асуудал давхар үүсдэг. Ядаргаа нь халдвар эсэргүүцэх болон өвчний эсрэг дархлааг муутгадаг. Мөн бодож сэтгэх, асуудал шийдэх болон гэр бүл, найз нөхөдтэйгөө цагийг зугаатай өнгөрүүлэх чадварыг муутгадаг. Амрах, бас тайвшрах цагтай байснаар ядаргаанаас урьдчилан сэргийлэх буюу түүнийг багасгахад тустай.



## Хоол тэжээлийн дутагдал

Урьдчилан мэдэх боломжгүй цагаар эсвэл олон цагаар ажилладаг хүмүүст шинэ хүнс авч хоол бэлтгэх цаг дэндүү бага байдаг. Тэд ихэвчлэн бэлтгэсэн хоол худалдан авах боломжгүй байдаг. Хэрвээ үйлдвэр нь хоолоор хангадаггүй, хүнс хадгалах газаргүй, аль эсвэл хоол идэх цаг байдаггүй бол ажилчид ихэвчлэн өлсөх буюу хэт боловсруулсан “түргэн хоол”-оор гэдсээ дүүргэдэг. (Хоол хүнс чухал болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг 28-р бүлэг. Эрүүл мэндэд тустай хооллолт хэсгээс үзнэ үү.)

Би өглөөний цайгаа  
уудаггүй, учир  
нь жаахан ч  
болов илүү унтах  
хэрэгтэй байдаг.



## Шинэ хүнс олох, худалдаж авах арга

Никарагуагийн Лас Мерседесийн экспортын бүсэд бид зөвхөн амьдрах мөнгөө олохын тулд өдөрт 12-14 цагаар ажилладаг. Оройтож, оройн цагаар



ажиллана гэдэг нь бид зах явж, шинэ хүнс авч чадахгүй гэсэн үг юм. Хэдэн жилийн өмнө хэсэг худалдаачид манай ажлын ойролцоо долоо хоног бүр шөнийн зах ажиллуулж эхэлсэн. Бид үүнд нь маш их дуртай байсан учир одоо өдөр бүр ажилладаг зах болсон. Зах ихэнх ажилчдыг тарснаас хойш

нэмж хэдэн цаг ажилласнаар бид өөрсдөдөө болон гэр бүлдээ илүү сайн хүнс худалдан авах боломжийг бий болгосон.

## Мансууруулах бодис

Ядарсан ажилчид өөрсдөө, эсхүл албадлагаар сэргээх мансууруулах бодис хэрэглэж ядрахгүйгээр үргэлжлүүлэн ажиллах чадвартай болдог. Зарим дарга нар ажилчдадаа капсул эсвэл уух усанд нь мансууруулах бодис хийж олон цагийн ээлжийн ажилд тэднийг унтахгүй, амрахгүй сэргэлэн байлгадаг. Эдгээр мансууруулах бодис нь таны зүрхний цохилтыг түргэсгэж, цусны даралтыг ихэсгэдэг. Мансууруулах бодис нь таны нойрыг сэргээх хэдий ч, юм идэх хэрэгтэй байхад өлсгөхгүй, амыг чинь ангуулж, мөн бие засахад хүндрэлтэй болгодог.

Манай байгууллага намайг шөнийн ээлжид ажиллах үед долоо хоногт нэг удаа “эрч хүчний ундаа” гэсэн капсул өгдөг. Дарга бидэнд хэлэхдээ эдгээр капсул нь витамин гэсэн боловч биднийг байнга нойрмог бус байлгах гэж өгч байгаа мансууруулах бодис гэдгийг нь бид мэддэг. Би хэдий нойрмог бус байгаа ч насад ямар ч эрч хүч байдаггүй. Гэртээ хариад би маш их ядарч байвч унтаж чаддаггүй.





## Шударга ажлын цагтай байх эрх



**ОУХБ, НҮБ** стандарт тогтоосон байдаг ч ихэнх улс орон өөрсдийн ажлын цагийг хуульчилсан байдаг.

**НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал**-д баярын өдрүүдэд цалинтай, амрах цагтай, бас ажлын цагийн хязгаартай байна гэж заажээ. **ОУХБ**-ын конвенцод хүмүүс долоо хоногт 40 цаг ажиллаж, амарч, цалинтай амралттай байх ба шөнийн цагийн ажлыг хязгаарлана гэсэн байдаг. Гэвч улс орон бүр өөрсдийн гэсэн хуультай байдаг учраас өөрийн орны хуулийг шалгаарай.

**ОУХБ-ын долоо хоногт 40 цаг ажиллах тухай конвенц (№47)**-ын дагуу ажилчид дараах эрхтэй:

- Долоо хоногийн дундаж ажиллах цаг 40 байна;
- Тогтмол ажлын цагтай ба амралтын хугацаатай;
- Долоо хоногт ажлын үргэлжлэх хугацаа 40 хүртэл цаг болж багассан байсан ч ижил цалин хангамжтай байх.

**ОУХБ-ын долоо хоног бүрийн амралтын тухай конвенц (№14)** нь ажилчдад долоо хоног бүр 1 өдөр (24 цаг) амрах эрх өгдөг. Амралтын өдөр нь уламжлалт байдлаар байх хэрэгтэй.

**ОУХБ-ын цалинтай амралтын тухай конвенц (№132)** нь жил бүр өвчтэй байсан өдөр эсвэл үндэсний баяр наадмыг үл харгалзан дор хаяж ажлын 3 долоо хоногтой тэнцэх цалинтай амралт авах эрхтэй байна.

- Ажилчид нь тогтмол цалинтай байх ба амралт эхлэх үед цалингаа авдаг байх ёстой;
- Ажил олгогч нь таны хэзээ амрахыг шийдэх боловч эхлээд тантай ярих ёстой;
- Хэрвээ та амралтаа огт авалгүйгээр ажлаасаа гарах буюу халагдсан бол ажил олгогч амралтын хугацааны мөнгийг заавал бодож олгох ёстой.

**ОУХБ-ын шөнийн ажлын тухай конвенц (№171)** -д шөнө дундаас өглөөний 5 цаг хүртэл 7 ба түүнээс дээш цаг ажиллах нь ажилчдад эрсдэлтэй гэж дурджээ.

- Шөнийн цагаар ажилладаг ажилчид илүү их цалинтай, илүү бага цаг ажилладаг эсвэл өөр бусад хангамжтай байх ёстой;
- 18 нас хүрээгүй ажилчид шөнө ажиллаж болохгүй;

- Өмнө нь шөнө ажилладаг байсан жирэмсэн ажилчид хүүхдээ төрсний дараа өдөр ажиллах, нийгмийн хамгаалал эсвэл цалинтай урт амралт зэрэг хувилбартай байх хэрэгтэй;
- Ажил олгогч шөнийн цагаар ажилладаг ажилчдынхаа эрүүл мэндийн талаар гэр бүлтэй нь уулзаж туслах болон нийгмийн үүрэг хариуцлагатай байх, санаачилга гаргах боломж олгох зэргээр хамгаалах ёстой;
- Анхны тусламжийн байгууллагууд шөнийн ээлжийн ажилчдад нээлттэй, мөн ажилчдыг яаралтай эмнэлэгт хүргэх ажлыг зохион байгуулах боломжтой байх ёстой;
- Та шөнө ажиллахаасаа өмнө болон ажиллаж байхдаа үнэ төлбөргүйгээр эмчид үзүүлэх эрхтэй. Хэрвээ та шөнийн ээлжид ажиллахад эрүүл мэндээр тохирохгүй байвал таныг ажлаас халах шалтгаан болохгүй.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ –ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

## Бага цалин нь хүмүүсийг ядуу байлгасаар байна

Хэрвээ шаргуу ажиллах тусам их мөнгө олдог байсан бол экспортын чиглэлийн үйлдвэрийн ажилчид дэлхийн хамгийн баян хүмүүс байх байлаа. Гэвч эдгээр үйлдвэрийн ажилчид туйлын ядуу амьдарч байна. Ажил олгогчид нь амьжиргааны доод түвшний орлогыг аль болох бага байлгахын тулд засгийн газрыг лоббидож, ажилчдад байж болох хамгийн бага цалинг өгч байна. Энэ нь хууль бус байж болох ч үйлдвэрийн эзэд ямар ч урамшуулал, илүү цаг эсвэл нийгмийн хамгааллын олговор өгөхийг эсэргүүцэж, ихэвчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ч бага цалин өгч байна. Засгийн газар нь компаниудыг үйлдвэрээ барьж тэдний нутагт байлгахыг хүсэж байгаа учраас ажилчдын цалин хөлс, ажлын цаг,

Би цэвэр устай,  
сургуультай, бас  
ойрхон эмнэлэгтэй газар  
амьдрах боломжгүй  
байна. Би арай гэж л  
гэр бүлээ хувиаслаж,  
тэжээж байна.



нөхөн олговор болон ажлын нөхцөлийн тухай хуулийг тэр бүр мөрдүүлэхгүй байна.

Компаниуд ажилчдадаа амь зуух төдий цалин өгөх үед тэд эрүүл саруул, хүн шиг нэр төртэй амьдрах эрхтэй гэж эсэргүүцдэг.

## Цалин олговрыг бүрэн олгохгүй байх

Ихэнх ажил олгогчид хуулиар заасан хамгийн бага цалинг ч бүрэн өгдөггүй. Зарим нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, илүү цагаар ажилласан нэмэлт хөлс, ажилласан цаг эсвэл хийсэн тоо ширхгээр нь тооцож, үндсэн цалинг нь бүтэн өгдөггүй. Хуулиар шаардсан ажлын ирц, амралт, баяр наадмын үеийн цалинг ч өгөхгүй байх тохиолдол бий. Тэгсэн хэрнээ ажилчид үйлдвэрийн дүрмийг зөрчсөн гэж торгуулдаг. Заримдаа үйлдвэрийн эзэн нь амралтын мөнгө өгөхөөс зайлсхийж, ажилчдын ээлжийн амралтыг зориуд баяр ёслолын үеэр тааруулсан байдаг. Энэ бол хууль бус юм.

Зарим ажил олгогч нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын төлбөрийг суутгаж цалин өгдөг ч нийгмийн даатгалын газарт мөнгө төлөөгүй байдаг. Ингэснээр ажилчид гэртээ илүү бага мөнгөтэй харьдаг дээрээ давхар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон бусад мөнгө төлсөн зүй ёсны нөхөн олговроо авч чадахгүй болдог.

---

Би нэг өдөр ажиллаагүйнхээ төлөө 3 өдрийн цалингаа алдсан. Учир нь тэд хууль бусаар миний ирцээс хасаж, бас цаг сайн барьсан урамшуулал болон хоолны эрхийн бичгийг хассан. Би нэг л өдөр ажиллаагүй байхад гараа долоо хоногт нь бүүр хоол идэх ч мөнгөгүй болсон.

---



## Илүү цагаар албадан ажиллуулах

Ажилчдын цалинг хийсэн тоо ширхгээр тогтоогоогүй хэрнээ үйлдвэрлэлийн өндөр нормыг заавал биелүүлж байж ажлын ээлжийг дуусгахыг зөвшөөрдөг.

Хэрвээ ажил олгогч ажилчдаас илүү цагаар ажиллахыг шаардаж, тэднийг шийтгэж, хүчээр илүү олон цаг ажиллуулдаг эсвэл ажлаа хийж дуустал нь үйлдвэртээ түгждэг бол энэ нь албадан хөдөлмөр юм. Албадан хөдөлмөр нь улсын болон олон улсын хүний эрхийн тухай хууль ба ажилчдын эрхийн гэрээг зөрчдөг.

*Миний ажилладаг Кенийн үйлдвэрт  
нормоо биелүүлээгүй бол гарахыг  
хориглодог. Заримдаа маш богинохон  
завсарлагатайгаар шөнөжин ажилладаг.*



Олон улсын компаниуд (брэндүүд) нь үйлдвэрүүдээс байж боломгүй хөдөлмөрийн хуваарьт хүргэхийг шаардсан гэрээ хийж, үйлдвэрүүдийг хүчээр илүү цагаар ажиллуулдаг. Илүү бага үнийг хайх энэ үйл явцад үйлдвэрийн эзэд өөрсдийн орлогыг баталгаатай байлгах, аль болох бага цалин өгөх арга замаар үйлдвэрээ ажиллуулдаг. Өгч буй цалин нь ихэнхдээ гэр бүлээ тэжээх нь байтугай нэг хүнд ч хүрэлцдэггүй учраас ажилчид илүү цагийн ажил болон урамшууллын нэмэлт цалингаас хүчээр хамааралтай болдог байна.

## Албадан хөдөлмөрийн хориг



**ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн эрхийн конвенц (№29),  
Албадан хөдөлмөрийг устгах конвенц (№105)-д байгууллагууд  
албадан цалингүй ажиллуулах эсвэл хүчирхийллийн аюул, өр болон  
бусад албадлагыг хэрэглэх нь хууль бус юм.**

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг  
Хавсралт А-д тайлбарлав.

## Хийснээрээ цалинжих нь ажилчдын эрүүл мэндийг хохироож байна

Хийснээрээ цалинжих систем нь ажил олгогчийн зүгээс ажилчдад ажилласан цаг эсвэл өдрөөр нь тооцож цалин өгөхийн оронд хэдийгээр ажилчид өвчтэй, ядарсан, гэмтсэн байсан ч гэсэн тэднийг хэт олон цагаар илүү их хурдтай ажиллуулахыг нь ажил олгогчдод хуулиар зөвшөөрдөг систем юм.

Хийснээрээ авах цалинг ихэвчлэн маш багаар тогтоосон байдаг учир ажилчид ердөө л амьдрах хангалттай мөнгө олохын тулд илүү цагаар ажиллах ёстой болдог. Тэд мөн ажилчдыг ус уулгахгүй, хоол идүүлэхгүй, мөн бие засах газар явуулахгүйгээр шийтгэж байдаг. Заримдаа тэд бүр хүчээр, цехийн хаалгыг нь түгжин тасралтгүй ажиллуулдаг.



## Зарим ажилчдад бусад ажилчдаас бага цалин өгдөг

Дарга нар зарим ажилчдыг эмэгтэйчүүд, уугуул иргэд, цагаач болон ажилчин хүүхдүүдийг ялгаварлан гадуурхаж, бусад ижил төрлийн ажил хийж байгаа хүмүүсээс бага цалин өгдөг. Эмэгтэй ажилчид дийлэнх нь байдаг, мөн тэд ажлыг

сайн хийж чаддаг ч илүү өндөр цалинтай ажилд дэвшүүлэх нь бага байдаг (399-401 дүгээр хуудсыг үзнэ үү).

## **Түр болон гэрээт ажилчид**

Хүмүүсийг ядуу байлгаж байгаа өөр нэг шалтгаан нь ажил олгогчид зөвхөн богино хугацаанд л ажилчдыг ажилд авч байгаа явдал юм. Тэд их ажилтай байх үедээ ажилчдыг ажилд авч, ажил байхгүй болонгуут халдаг. Ажил олгогчид нь ихэвчлэн түр хугацааны агентлагуудаар дамжуулан ажилчдыг ажиллуулж, шууд ажил олгогч нь болох хуулийн үүрэг хариуцлагаас зайлсхийдэг.

Энэ систем нь ажилчдыг жинхэлж, хуулийн ашиг тусыг хүртэх боломжийг нь алга болгодог. Учир нь гэрээт болон түр ажилчид ирж л байдаг, явж л байдаг учир энэ нь ажлаас шалтгаалж байгаа өвчлөл болон гэмтэл бэртлийг нуун дарагдуулж, ажилчид нэгдэн илүү сайн, аюулгүй нөхцөлийг бий болгоход хүндрэл учруулдаг.

## **Өр төлөхийн тулд ажиллах**

Хэтэрхий бага цалин авч байна гэдэг нь ажилчид онцгой нөхцөл байдалд хангалттай мөнгө авч, хадгалж чадахгүй эсвэл хэрэгцээт зүйлсээ худалдан авах боломжгүй гэсэн үг юм. Үйлдвэрийн ойролцоо байдаг дэлгүүрүүд ихэвчлэн зээлээр бараа авах боломжтой байдаг ч зээлийн хүү өндөр. Ажил олгогчид, банкууд, мөнгө хүүлэгчид зээлийг өндөр хүүтэй байлгадаг. Ажилчид асар их хүүнээс болж өртэй болсон байдаг тул тооцоогоо төлөх үед амь зуух төдий бага мөнгөтэй үлддэг. Тиймээс тэд илүү их зүйл зээлээр авах, аль эсвэл өөр газраас зээл авах болдог.

Цагаач ажилчид ч мөн зээлийн системийн хохирогчид болдог. Ажилд зуучлагчид нь тэднийг өөр оронд ажилтай болгохдоо их мөнгө төлөхийг сануулж, түүнийгээ өр болгон бүртгэдэг. Ажилчид ирсэн даруйдаа л өрөө төлж эхэлдэг. Гэвч ажил зуучлагчид болон ажил олгогчид тэднээс илүү их мөнгө шаардаж, зээлийн хүүг нэмэх юм уу, зээлийн гэрээг дураараа өөрчилдөг. Зарим ажилчид энэхүү системийн занганд орж, хэзээ ч өрөө төлж дуусгах боломжгүй болдог. Үүнийг “өрийн боолчлол” гэдэг.

### Хадгаламжийн бүлэг нь ажилчдыг өрнөөс гарахад тусалдаг

Кавита даргаасаа авсан зээлээ төлж дуусгахын тулд маш удаан ажиллаж байгаа ч түүний өр багасах шинжгүй байв. Олонх эмэгтэйчүүд яг ийм нөхцөл байдалд байсаар байна. Нэг өдөр Санкапын бүлгийн зохион байгуулагч уулзаж, өрөө хэрхэн төлөх арга замын талаар ярилцсан юм. Зохион байгуулагч тэдэнд хадгаламжийн бүлэг нээж ажиллуулах санал тавив. Арван эмэгтэй хамт ажиллавал долоо хоногт 1 рупи хадгалж чадна гэж тэр хэлэв. Зохион байгуулагч тэдэнд банкны данс нээхэд нь тусална гэв. “Хэрвээ тэд тогтмол хадгаламжаа хийвэл банк ч тэдэнд даргаас нь хамаагүй дээр нөхцөлөөр зээл өгөх болно” гэлээ.

Эмэгтэйчүүд нэгдэн долоо хоногт 1 рупи хадгалж байв. Гурван сарын дараа тэд нэг эмэгтэйн өрийг төлөхүйц мөнгөтэй болсон бөгөөд энэ удаад Кавитаг сонгов. Кавита ба бусад эмэгтэйчүүд үргэлжлүүлэн мөнгөө хадгалж, хэдэн сар тутамд өөр хэн нэгнийхээ өрийг төлж байв. Бүх эмэгтэйн өрийг төлж дууссаны дараа үргэлжлүүлэн хадгалж, дарга эсвэл банкнаас зээл авахаар явахын оронд бие биендээ зээл өгч байв. Одоо тэд онцгой нөхцөл байдал тулгарахад урьд өмнөхөөсөө илүү бэлтгэлтэй болжээ.

## Үйл ажиллагаа

## Цалингаа шалгах

Таны гар дээрээ авсан бүх мөнгө чинь олсон бүх мөнгө чинь мөн үү гэдгийг олж мэдэх боломжтой юм. Энэ үйл ажиллагаа нь танд дараах байдлаар тус болно:

**Хэр зэрэг цалин авахаа мэдэх хэрэгтэй.** Ажил олгогч танд цаг бүр, нэгж бүр эсвэл өдөр бүр мөн илүү цаг бүрт хэдий хэр мөнгө өгөх ёстойг олж мэд. Мөн амралтын цалингийн хэмжээ болон жил бүр цалин нэмэгдэх эсэхийг олж мэд.

**Юу хасагдахыг мэддэг байх.** Таны цалингийн зарим хэсэг татвар, нийгмийн даатгал, хадгаламж эсвэл орон сууцанд хасагдаж, мөн ажил олгогч чинь таны авах ёстой зөв дүнгээс хасалт хийсэн үү гэдгийг шалга. Хамтран ажиллагчдаасаа тэдний татвар, нийгмийн даатгалын суутгал таныхтай ижил байна уу? гэж асуу. Үйлдвэрчний



эвлэлээсээ болон хуульчаас ажил олгогч тань танд хуулийн дагуу зохих ёсны цалин өгч байгаа эсэхийг хянаж өгнө үү гэж хүс.

**Бүртгэл хөтлөх.** Бүх ажилласан цаг, хийсэн тоо ширхэг, хийсэн бүтээгдэхүүн бүрийн үнэ, бусад хэрэг болох мэдээллийг тэмдэглэлийн дэвтэр юм уу, календарь дээр бич. Цалингийн чек, банканд мөнгө хийсэн баримт болон цалингийн талаарх бусад мэдээлийн хуулбарыг хадгал.

**Цалингаа тооцоолох.** Хийсэн ширхэг ажил бүрийн бүртгэл эсвэл ажилласан өдөр, цагаа тооцон хэр их мөнгө авахаа тооцоолж чадна.

### Цагийн бүртгэл хийх

Ажилласан болон ажиллаагүй цагаа бүртгэх Хуудас гарга (эсвэл хуанли). Өөрийн нөхцөл байдалд тохирсон хүснэгт (доорх жишээ зургийг үз) нэм. Жишээлбэл, хийсэн тоо ширхэг эсвэл урамшуулал бүртгэх багана нэм.

Өдөр	Огноо	Ирсэн	Явсан	Ердийн цаг	Илүү цаг	Хийсэн тоо ширхэг
Даваа	6-4	7.00	17.30	8	2	160
Мягмар	6-5	7.00	19.30	8	4	220
Лхагва	6-6	7.00	19.30	8	4	220
Пүрэв	6-7	7.00	17.30	8	2	170
Баасан	6-8	7.00	17.30	8	2	170
Бямба	6-9	7.00	11.00	4		60
Ням	6-10	-	-	0	0	
Нийт цалинтай цаг				44	14	1000

Та хийснээрээ эсвэл ажилласан цагаараа алинаар нь ч цалин авдаг бай, ажил олгогч нь дор хаяж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалин дээр нэмж илүү цагийн хөлс өгөх ёстой. Доорх цалингийн үнэлгээнүүд нь зөвхөн жишээ юм.

### Хэрвээ ажилласан цагаараа цалинждаг бол:

1. Танай улсын хуулийн дагуу долоо хоногт ажиллах хугацаа хэд вэ? Та хэр их ажилласан бэ;
2. Ердийн цагийг авах ёстой цалиндаа хуваа;
3. Илүү ажилласан цагаа илүү цагийн цалингийн үнэлгээгээр үржүүл;
4. Долоо хоног бүрийн ердийн цаг болон илүү цагийн цалингаа нэм;
5. Энэ долоо хоногт олсон урамшуулал буюу үйлдвэрлэлийн зорилгод хүрсэн, цаг сайн барьсан эсвэл хоолны тэтгэмж зэргийг нэм;
6. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын татвар, хураамжийг хас. Жишээг дор үзүүлэв:

### Хэрвээ та хийснээрээ цалинждаг бол:

1. Хийсэн бүх тоогоо нэг бүрт өгөх цалиндаа үржүүл;
2. Энэ долоо хоногт олсон урамшууллаа нэм;
3. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын татвар, хураамжийг хас.

Манай улсад хуулийн дагуу долоо хоногт 44 цаг ажилладаг. Би 58 цаг ажилласан.

Би энэ долоо хоногт 110\$ авахаар байгаа.  
Тэгэхээр  $110\$/44 \text{ цаг} = \text{цагт } 2,50\$$ .

Илүү цагт ердийн цагаас 1,5 дахин илүү төлдөг.  
Тэгэхээр  $2,50\$ \times 1,5 = 3,75\$$

Би 14 цаг илүү цаг ажилласан. Тэгэхээр  
 $14 \times 3,75\$ = 52,50\$$  (илүү цагийн цалин)

$110\$$  (ердийн цалин)  $+ 52,50\$$   
(илүү цагийн цалин)  $= 162,50\$$

$162,50\$ + 20\$$  цаг барьсан урамшуулал  
 $+ 20\$$  үйлдвэрлэлийн зорилгод хүрсэн  
урамшуулал  $= 202,50\$$

202,50\$

- 20\$ татвар

-25\$ нийгмийн даатгал

$= 157,50\$$  долоо хоногийн цалин.

$1000 \text{ ширхэг} \times 0,15\$ = 150\$$

$150\$ + 20\$$  үйлдвэрлэлийн зорилгод хүрсэн  
урамшуулал  $= 170\$$

$170\$ - 30\$$  нийгмийн даатгал

$= 140\$$  долоо хоногийн цалин.

## Цалингаа бүрэн авах

Өөрийн цагийн бүртгэл болон авсан цалингийнхаа чек бүрийг цалингийн задаргаатай харьцуулж бай. Хэрэв та өөрийн тооцоолсон цалингаа авч чадахгүй бол:

- **Нягтлантайгаа ярилцаж** (эсвэл ахлагчтай) өөрийн болон тэдний бүртгэлийн ялгааг асуу. Үүнд гэрээ эсвэл тодорхойлсон цалин болон хасалтыг бичсэн тооцоог авчрах нь тус болох ч таны бичсэн цагийн бүртгэлийг танд цалин өгч байгаа хүнийхтэй жиших нь илүү дээр юм. Таныг дэмжих болон гэрчлэх хамтран ажиллагчаа байлга;



- **Үйлдвэрчний эвлэл, ажилчдын холбоо эсвэл бусад байгууллагаас тусламж, зөвлөмж хүс.** Үйлдвэрийн талаар (нэр, хаяг, эзэд) аль болох их мэдээлэл авчрах нь хуулийн заргын үйл ажиллагааг эхлэхэд илүү хялбар болгодог. Дарга тань магадгүй танд төлж байгаагаа хуулийн дагуу гэж бодож байж болох ч хэрвээ үгээр болон бичгээр юу амласан цалин нь биш бол үүнийг засахын тулд та нийгмийн дарамт, ажилчдын үйлдвэрчний эвлэлийн эсвэл хуулийн аргаар шаардаж болох юм;
- **Бусад ажилчидтай ярилц.** Хэрвээ зөв цалин авахгүй байвал бусад ажилчид ч мөн ижил нөхцөл байдалд байна гэсэн үг. Хамтдаа ярилцаж, бие биенээ дэмжин үүнд шийдэл ол.

### Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хангалтгүй юм

Би Мексикийн Сиудад Акуна ТВ-ийн үйлдвэрт ажилладаг ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага зэрэг дээгүүр цалин авдаг. Комите Фронтеризо дэ Обreras (CFO)-ын нэг сургалтын үеэр бидний тогтвортой амьдрах цалинг тогтоох үйл ажиллагаа болсон юм. Бид өөрсдийн долоо хоногийн зарлагыг үзэж, “амьдрахад зайлшгүй хэрэгцээ” буюу ерөнхий хүнс, цэвэр ус, ариун цэврийн хэрэгслүүд, “сар бүр төлөх хэрэгтэй зүйлс” буюу цахилгаан, түрээс, тээвэр мөн бусад “нэр төртэй амьдрахад хэрэгтэй зүйлс” буюу илүү тэжээллэг, чанартай хүнс болон сургуулийн төлбөр зэрэгт хуваасан юм. Бид долоо хоногт хэд хэрэгтэй болон хэдийг бид олж байгааг харьцуулахад, хэдий бид бүх зүйлсээс олон юм оруулалгүйгээр хамгийн хямдхан брэндийг сонгож байсан ч бид хэрэгтэй зүйлсийнхээ дөнгөж 25 хувийг олж байв. Одоо CFO нь ажилчид

(үргэлжлэл)

болон тэдний гэр бүлийг тогтвортой, эрүүл амьдрахад хангалттай орлоготой байлгахын тулд бүтэн цагаар ажилладаг ажилчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Өөрийн бүх зардлыг төлөхөд **танд** хэр их мөнгө хэрэгтэй вэ?

## Амьдрахад хүрэлцэхүйц цалин авах нь хүний эрх юм

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэж амьдрах газар, ус, ажилчид өөрийгөө болон гэр бүлээ тэжээх хүнс зэрэг ерөнхий хэрэгцээнд хүрэхүйц мөнгийг хэлнэ. Гэвч хүмүүс амь зуухаас илүүг хийх хэрэгтэй. Бидэнд боломжийн гэр орон, бидний гэр бүлд хангалттай шим тэжээлтэй, эрүүл хүнс, сарын төлбөр буюу том худалдан авалт эсвэл онцгой нөхцөлд хэрэглэхэд зориулсан, хадгаламжид хийхүйц хангалттай цалин хэрэгтэй. Амьдрахад хүрэхүйц цалин нь ажилчид болон тэдний гэр бүлийг ядуурал, өвчлөл гэсэн үйлтэй тойргоос гарч, эрүүл саруул амьдрах боломжийг олгодог.



### Амьдралын стандарт



НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхагт бүх хүн нийгмийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, орон сууц, хувцас, хүнс болон эрүүл саруул аж төрөх стандартад нийцэх амьдрах боломжоор хангагдсан байх эрхтэй гэж заасан байдаг.

ОУХБ-ын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг засварлах конвенц (№131)-д заахдаа засгийн газар дараах зүйлийг хийх ёстой гэжээ:

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоохдоо бүх ажилчид, мөн ажилчдын хэрэгцээ, тэдний гэр бүлийг харгалзах;
- Ажилчид зөв цалинжиж байгааг баталгаажуулж, хуулийг сахиулах.

ОУХБ засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтооход ийм шаардлага тавьдаг ч бүх улс орон өөрсдийнхөөрөө шийддэг. Өөрийн орны хөдөлмөрийн хуулийг шалга.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ –ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

## Азийн орнуудын цалингийн доод хэмжээг тогтоох кампанит ажил


Олон улсын компаниудын анхаарлыг хямд үнээр татахын тулд үйлдвэрүүд нь хотоос хотод, улсаас улсад дамжин бага цалин өгч болохуйц хууль эрхийн зохицуулалт муутай улс орнуудыг хайж байдаг. Энэхүү “уралдаанд уралдах”-аас залхсан ажилчид хамтдаа Ази даяар Азийн орнуудын цалингийн кампанит ажлыг эхлүүлсэн юм.

Тэд улс орон бүрт ажилчид өөрийн гэр бүлээ тэжээхийн тулд долоо хоногт 48 цагаас хэтрэхгүйгээр хэдий хэр мөнгө олох ёстойг тооцоолов. Тэд Азийн орнуудын хөдөлмөрийн хөлсийг Азийн том компаниуд илүү хямд үнийг хайж явахааргүйгээр ижил тогтоосон юм. Зарим ажилчид хөдөлмөрийн хөлсний доод үнэлгээг ашиглан үйлдвэрийн эзэд, менежерүүдтэй илүү дээр цалин авах талаар тохиролцон, брэндүүдийг хамгийн бага үнийн төлөө биш, ажилчдын сайн сайхны төлөө болгож журмаа өөрчлөхийг шаардаж байна.

## Олон цагаар ажиллах нь зохион байгуулалтад ороход хүндрэл учруулдаг

Хэт олон цагаар ажиллуулж байгаагийн эсрэг хэрхэн нэгдэж чадах юм бэ, угаасаа үүнийг хийх цаггүй хүмүүс яах вэ? Тэгвэл дараах тактик нь үүнийг хийхэд тус болно:

- **Ажиллагчдад ажил болон гэрийн үүрэгт ажлаа хийхэд харшлахгүй байх тохиромжтой газар болон цагийг ол.** Ажиллагчдын уулзалтыг ажлын бус өдөр төлөвлө. Нэг цагт, нэг газар бүх хүнд тохиромжтой байлгах гэхийн оронд хэд хэдэн жижиг уулзалтууд хий. Ээлжээр нь, ажлаар нь эсвэл хөршөөр нь уулзалтыг зохион байгуул;
- **Уулзалтыг ажлаас гадуур зохион байгуул.** Ажлын завсарлагаанаар ажиллагчидтай ярилц. Өөр өөр хэсэг бүлэг хүмүүстэй өдрийн цайны цагаар уулзан, бусдын үйл ажиллагааг урамшуулж,



шинэ найзуудтай бол. Ажлын өмнө, ажлын дараа буюу автобусанд, үдэшлэг цуглааны үеэр, аль эсвэл ажилчдын амьдардаг газрын ойролцоо ажилчидтай уулз, холбогд;


- **Эмэгтэйчүүдийг оролцуул.** Учир нь эмэгтэйчүүд ихэвчлэн “хоёрдугаар ээлж”-д ажилладаг ба гэр бүлдээ анхаарал тавьдаг учир тэднийг оролцуулах нь илүү хэцүү байдаг. Уулзалтын үеэр хүүхэд харах үйлчилгээ болон шинэ хүнс, ундаа идээ санал болгосноор тэднийг оролцуулахад илүү хялбар болно.

### Ажилчид амралтын өдөртэй болж чадлаа

Бид Шри Ланкийн Синотехс үйлдвэрт Nike гутал үйлдвэрлэдэг. Дарга биднийг долоо хоногт ямар ч амралтгүй ажиллуулдаг. Шри Ланкийн хөдөлмөрийн тухай хуулиар бол долоо хоног бүр нэг өдөр амрах ёстой байдаг.

Үйлдвэрчний эвлэл болон Ажилчдын зөвлөлийн гишүүд хуулиар олгогдсон амралтын өдрөө нэхсэн ч дарга эсэргүүцээр байв.

Бид ажилчдад хуулийн заалт болон Nike брэндийн ёс зүйн дүрмийн талаар тайлбарлан хэлж өгч, долоо хоногт нэг өдөр амрах эрхтэйг нь ойлгуулав. Улмаар Nike брэндийн удирдлагад энэ тухай мэдээлнэ гэж айлгав. Nike-аас шалгалт ирсэн ч байдал дээрдсэнгүй, дарга ч өөрийнхөө байр суурийг хамгаалсаар байв. Дарга Nike гэрээгээ цуцлах гэж байгаа гэж биднийг айлгасан ч арга буюу хүчин мөхөстөж, бидний тэмцэл эхэлснээс хойш нэг сарын дараа долоо хоногийн эцэст амрахыг зөвшөөрөв.



Зарим нь амралтын өдөртэй болсондоо баярлаж байсан ч, зарим ажилчид бүтэн сайнд амрах болсноор цалин буурлаа гэж гомдоллож байв. Бид цалингаа нэмэгдүүлэхээр тэмцэнэ гэдгээ амлав.

## Сайн цалин ба ажлын цагийг шударгаар тооцохын төлөөх тэмцэл

Хамтын гэрээний төлөө тэмцэж, ялж чадсан үйлдвэрийн ажилчид нь ихэвчлэн илүү сайн цалин, илүү шударга ажлын цагийн тухайд хэлэлцээр хийх боломжтой болдог. Үйлдвэрчний эвлэл болон ажилчдын үйлдвэрчний эвлэлийг үүсгэн байгуулах нь илүү цаг, шударга цалин, мөн хамтын гэрээ хийхэд хамгийн тохиромжтой сайн арга юм.



**Хамтын гэрээг тохиролцох үед та болон ажил олгогч нь үүнийг хүндэтгэн баталдаг.**

## Хөдөлмөрийн хуулийг хэрэгжүүлэх

Хөдөлмөрийн тухай хууль нь олон оронд ажиллах цаг болон илүү цагийн хязгаарыг тогтоож өгдөг. Хэдий тийм ч экспортын чиглэлийн олон үйлдвэр, нэн ялангуяа экспортын онцгой бүс доторх үйлдвэрүүд нь эдгээр хуулиас чөлөөлөгддөг. Үйлдвэр нь хуулийг хэрэглэдэг ч бай, үгүй ч бай ажилчид нь ажлын цагийг шударгаар тооцохын төлөө үйл ажиллагаа өрнүүлэн шаардлага тавих нь үйлдвэрийн зүгээс та нарыг хүндэтгэн үзэх хангалттай үндэслэл болж чадна.

Хэрвээ Хөдөлмөрийн тухай хууль нь сул эсвэл үүнд цалин хөлсний болон ажиллах цагийн тухай заалт байхгүй бол ажлын цагт хязгаар тогтоож, ажилчдыг хамгаалах хууль бий болгож, баглахыг шаардах хэрэгтэй. Танай орны нэгдсэн олон улсын гэрээ хэлэлцээрт хөдөлмөрийн болон хүний эрхийн тухай стандарт заалтууд байдаг ба тэдгээр стандартыг хэрэгжүүлээгүй байгаа ч гэсэн танай үйл ажиллагаанд эдгээр заалт хэрэг болно. Хавсралт А: Зохистой, эрүүл, шударга ажлын төлөөх тэмцэл ба хууль тогтоомж хэсгийг үзнэ үү.

## Олон нийтийн үйл ажиллагаа

Үйлдвэрийн ажилчдын үйлдвэрчний эвлэл нь ихэвчлэн олон нийтийн бүлэг болон төрийн бус байгууллага (NGO) буюу эмэгтэйчүүдийн, шашны, хүрээлэн буй орчны эсвэл хүний эрхийн холбоодоор хүчээ зузаатгадаг. Бага цалин хөлс, урт ажлын өдрүүдээс болж үүсэж байгаа асуудлуудыг хэлэлцэж, тэдний нөхцөл байдлыг сайжруулахад олон нийт, хүн бүрийн санааг дэвшүүлж ажиллагчдыг дэмжиж, тусалдаг. Гэвч яагаад? гэдгийг ашигла. Хуудас 35-аас доорх асуудлуудыг шийдвэрлэхэд хэрхэн туслах талаарх дасгал ажлыг үз. Ажиллагч болон олон нийтийн холбоо нь олон төрлийн төсөл, үйл ажиллагаа зохион байгуулдаг.

- **Хууль зүйн тусламж үзүүлэх төв:** сайн дурын хуульчид болон хуулийн оюутнууд ажилладаг ба тэд маш олон асуудал, ялангуяа Хөдөлмөрийн тухай хуулийн зөвлөгөөг санал болгодог.
- **Хямд үнэтэй хүүхэд асрах газар, сургуулиас гадуурх арга хэмжээ, сургалтын төв:** эдгээр газар нь хэдий та илүү цагаар болон шөнө ажиллаж байсан ч хүүхдийг тань аюулгүй байлгаж, сургаж байдаг.
- **Шөнийн болон амралтын өдрийн насанд хүрэгчдийн үнэ төлбөргүй сургууль:** тэд таны аль боломжтой үед сурахыг хүсэж байгаа зүйлийг тань зааж өгөх болно.
- **Олон нийтэд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ ба лавлагаа:** тэд танд эрүүл мэндийн үйлчилгээ авахад илүү хялбар, бас хямд байх боломжийг олгоно.
- **Шөнийн зах, олон нийтийн цэцэрлэг болон хүнс шуудайгаар нь худалдах авах:** тэд танд үнийг нь хямдруулж, илүү шим тэжээлтэй хүнс



хэрэглэхэд тань тус болно.

- **Соёлын үйл ажиллагаа:** тэд таныг бусад ажилчидтай холбоотой байж амьдралаас баяр баяслыг мэдрэхэд тань тус болж чадна.



## Олон улсын үйл ажиллагаа

Маш олон ажил олгогч, брэндүүд нь өөрсдийн бүтээгдэхүүнээ дэлхий даяар зардаг тул дэлхийн бусад орны үйлдвэрчний эвлэл, нэгдлүүд ч нэгэн адил цалин нэмэгдүүлэх үйл ажиллагаа, компаниуд цалингаа өгч, ажилчдад өгөх ёстой үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг шаардлага тавьсан үйл ажиллагаагаараа танигдаад байна. (илүү дэлгэрэнгүй мэдээллийг 86-р хуудаснаас үзнэ үү).

### Албадан илүү цагаар ажиллуулахын эсрэг бид хэрхэн ТЭМЦЭЖ ЯЛАВ

Хувцасны бусад үйлдвэрийн ажилчид биднээс та нар яаж албадан илүү цагаар ажиллахгүй 4.30-д тардаг болсон бэ гэж асуудаг. Бид үйлдвэрчний эвлэлээ зохион байгуулж, амжилтад хүрсэн талаар хүмүүс мэдэж авах үедээ тэд ч мөн илүү сайн нөхцөлийн төлөө тэмцэх боломжтой юм байна гэдгээ ойлгож биднийг хэрхэн үүнийг хийв гэж асуудаг.



### Бусад ажилчидтай туршлагаа хуваалцах

Бид Гватемалад Чой Шин болон Симатекстайлийн үйлдвэрт ажилладаг. Энэ хоёр үйлдвэр хоёулаа нэг дор байдаг ба нэгэн солонгос компани эзэмшдэг

байв. Энд олон хүн муу нөхцөлд ажилладаг байв. Үүний хажуугаар ууртай даргатай, мөн бага цалин өгдөг хэрнээ тэд биднийг хүсээгүй байсан ч илүү цагаар албадан ажиллахыг шаарддаг байв. Бидний зарим нь үйлдвэрийн энэ нөхцөл байдлын талаар ажлын гадаа зогсож байгаад ярилцдаг байв. Бид, дарга ажил дээр бидэнд хэрхэн ханддаг, бид хэр хэмжээний цалин



(үргэлжлэл)

авдаг, хэр ойрхон биднийг хүчээр илүү цагаар ажиллуулдаг байсан гээд бүх зүйлийн талаар ярилцав. Бүгд зовлонгоо ярих боломж олдсоны дараа бидний хуваалцсан асуудлуудаас хамгийн том нь албадан ажиллуулсан илүү цагтаа бид маш бага цалин авдаг явдал юм байна гэж тогтлоо.

### Ажилчдын үйлдвэрчний эвлэлийг зохион байгуулах

Анхандаа бидний хэн нь ч ажлаа алдах вий гэдгээс айж, даргын эсрэг ямар нэгэн аргаар эсэргүүцэл үзүүлэхийг хүсэхгүй байв. Гэвч Гватемалад албадан илүү цагаар ажиллуулж байсан нь хууль бус гэдгийг олж мэдсэн үеэс бид үйлдвэрийн гаднах хөрш ажилчидтай жижиг баг болон үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Нэг жилийн дараа гэхэд манай үйл ажиллагаанд 1250 ажилчид хоёр үйлдвэрээс элссэн байв. Бид бүгд Бие даасан үйлдвэрчний эвлэл гэсэн нэрэн дээр тохирсон юм.



### Асуудалд анхаарлаа хандуулах

Бид олон нийтийг үйлдвэрт болж байгаа асуудлын талаар ойлголттой болгосон юм. Дарга нар үүний хариуд заналхийлэл, авлига, тэр бүр хэл бидний удирдагч нарыг хүчирхийлэхээр сүрдүүлж, бидний нэгдлийг устгахаар завдаж байв. Хоёр ч удаа ахлагчаар удирдуулсан үйлдвэрчний эвлэлийн бус дээрэмчид биднийг сүрдүүлж халдсан боловч бид олон нийтээс хамгаалалт дэмжлэг олж чадсан.



## Улсын болон олон улсын дэмжлэгийг бий болгох

Манай үйлдвэрчний эвлэл Гватемала ба бусад улсын үйлдвэрчний эвлэл болон нэгдэлтэй холбоо тогтоосон юм. Бид мөн брэндүүд рүү захиа бичсэн. Тэд дарга нараас ажлын нөхцөлийг сайжруул гэж шаардсан билээ. Дарга нар ч өөрсдийн үйлчлүүлэгчээ хадгалж үлдээхийн тулд бидний болон манай үйлдвэрчний эвлэлийн гэрээ хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурахаас өөр аргагүй болсон юм.

## Хууль сахиулахыг шаардах

Гэвч удалгүй дарга үйлдвэрчний эвлэлийн удирдагч нарыг дахин дарамталж, үйлдвэрээ хааж Хятад руу нүүх болно гэж сүрдүүлсэн юм. Гэвч бид үйлдвэртээ үргэлжлүүлэн ажиллаж, бас үйл ажиллагаагаа явуулсаар байв. Хоёр жилийн турш тэмцэж, засгийн газрыг хуулиа сахиул гэж олон нийт, улсын болон олон улсын байгууллагууд шаардаж байв. Засгийн газар, үйлдвэрийн эзэн, бид хамтын гэрээ хэлэлцээр хийж, үйлдвэрчний эвлэлийн халагдсан ажилтнуудыг дахин ажилд авч, бидний санал гомдлыг шийдвэрлэ гэж хэлсэн юм.



## Зарим нь ялж, зарим нь ялагдана

Хэдийгээр бид илүү өндөр цалинтай, дахин албадан илүү цагаар ажиллахгүй болсон ч манай үйлдвэрчний эвлэлийг үзэн яддаг, үйлдвэрээ хаагаад өөр тийшээ нүүнэ гэж дарамталдаг дарга болон бидний хооронд тэмцэл байсаар байв. Гэвч бид Гватемалад хамтын гэрээтэй анхны үйлдвэрчний эвлэл болсноороо бахархаж байна.

Дээрх үйл ажиллагааг хэрхэн алхам алхмаар зохион байгуулах талаар 80-86 дугаар хуудсыг үзнэ үү.